



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.04.29 № 440  
танай \_\_\_\_\_-Ы № \_\_\_\_\_-Т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗАРТ**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт <sup>27</sup> хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Ч.ЭРДЭНЭБААТАР



023030408



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

## ХЭНТИЙ АЙМГИЙН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

*Аймгийн төсвийн нийт орлого 24,281.5 сая төгрөгөөр буюу 162.9 хувиар давж биелсэн нь улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулах боломжтой байна.*

**АУДИТЫН КОД: ХЭА-2022/01/НА-СТА-НТГ**

Чингис хот 2022 он  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**Тэргүүлэх аудитор:** Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112  
**Аудитын менежер:** Д.Оюунтуяа  
Утас: 99775390  
**Аудитор:** Б.Ариунаа  
Утас: 93032714  
**Аудитор:** Х.Еркегүл  
Утас: 99040705

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

[khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу.

<p><b>Тайланг бэлтгэсэн:</b> Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p><b>Дарга, тэргүүлэх аудитор</b> Ч.Эрдэнэбаатар</p> <p><b>Аудитын менежер</b> Д.Оюунтуяа</p> <p><b>Аудитор:</b> Б.Ариунаа Х.Еркегүль</p> <p><b>2022 оны 04 сар</b></p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70562147, 70562112 дугаарын утас, <a href="mailto:khentii@audit.gov.mn">khentii@audit.gov.mn</a> хаягаар харилцана уу.</p> <p><b>ХАЯГ:</b> Хэнтий аймгийн Хэрлэн сум, аймгийн ЗДТГ-ын байр, 315 тоот</p>	<p style="text-align: center;"><b>ТАЙЛАНГИЙН АГУУЛГА</b></p> <p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b> Үндсэн мэдээлэл.....2</p> <p><b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.</b></p> <p>1.1 Дээд шатны төсөвт тодотгол хийгдээгүй байхад 3,991.0 сая төгрөгөөр төсвийг тодотгосон нь хуульд нийцэхгүй байна.....5</p> <p>1.2 Сумын төсвийн орлогод төвлөрүүлсэн 617.8 сая төгрөгийн орлогыг аймгийн төсвийн бусад орлогод татан төвлөрүүлсэн нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.....6</p> <p>1.3 Сум хөгжүүлэх сангийн орлогыг 1,639.6 сая төгрөгөөр төвлөрүүлж, биелэлт 108.5 хувьтай байгаа нь “Бусдадаа боломж олгоё” аяны үр дүн байна.....9</p> <p><b>БҮЛЭГ 2. НИЙТ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 89.9 ХУВЬТАЙ БАЙНА.</b></p> <p>2.1 Тодотголоор тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийг зохистой удирдаагүй, төлөвлөлт, хуваарилалтыг үндэслэлгүй хийсэн байна.....10</p> <p>2.2 Батлагдсан төлөвлөгөөнөөс Сум хөгжүүлэх сан 30.5 хувь, Жижиг дунд бизнесийг дэмжих сангийн 26.2 хувийн зарцуулалттай байна. 13</p> <p><b>БҮЛЭГ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ</b></p> <p>3.1 Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 230.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 199.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна. ....17</p> <p>3.2 Эрүүл мэндийн салбарын шинэчлэл орон нутагт эхлээгүй, коронавируст халдварын эмчилгээний зардалд 7,321.8 сая төгрөгийг санхүүжилт авсан байна.....18</p> <p><b>БҮЛЭГ 4. ӨМНӨХ АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА.</b></p> <p>4.1 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.....18</p> <p><b>Аудитын дүгнэлт.....20</b></p> <p><b>Зөвлөмж.....21</b></p> <p><b>Хавсралтууд.....</b></p>
--	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	
<b>АИТХ</b>	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>АТӨЯХ</b>	Автотээвэр өөрөө явагч хэрэгсэл
<b>БОАЖЯ</b>	Байгаль орчин аялал жуулчлалын яам
<b>БОНАТ</b>	Борлуулалтын орлогод ногдох албан татвар
<b>БТСГ</b>	Биеийн тамир спортын газар
<b>БХБС</b>	Барилга хот байгуулалтын сайд
<b>БХС</b>	Байгаль хамгаалах сан
<b>БШУС</b>	Боловсрол, Шинжлэх ухааны сайд
<b>ГБХЗХГ</b>	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЖДБДС</b>	Жижиг дунд бизнесийг дэмжих сан
<b>ЗАА</b>	Захирагчийн ажлын алба
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>МУЕА</b>	Монгол улсын ерөнхий аудитор
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>ОНӨА</b>	Орон нутгийн өмчийн алба
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ОНХНС</b>	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>СӨБ</b>	Сургуулийн өмнөх боловсрол
<b>СТСХ</b>	Санхүү төрийн сангийн хэлтэс
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТЕНБ</b>	Төсвийн ерөнхий нягтлан бодогч
<b>ТТАМ</b>	Түгээмэл тархацтай ашигт малтмал
<b>ТТЗ</b>	Төсвийн төвлөрүүлэн захирагч
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ҮҮЗАУс</b>	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус
<b>ҮҮХХБ</b>	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар
<b>ҮХХ</b>	Үл хөдлөх хөрөнгө
<b>ХНХС</b>	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
<b>ЭМДС</b>	Эрүүл мэндийн даатгалын сан
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв

## Аудитын тайлан

### Ерөнхий зүйл

**Аудитын нэр:** “Хэнтий аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”

**Аудитын код:** ХЭА-2022/01/НА-СТА-ТЕЗ

### Аудитын хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/29 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт:

Хэнтий аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх
2. Орон нутгийн төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан эсэх
3. Нэмэлт санхүүжилтийн талаар
4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажилласан эсэх

### Хамарсан хүрээ:

Аудитыг аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэнцэл, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Татварын орлогын гүйцэтгэлийн мэдээ болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан аудит хийв.

### Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, судалгаа тодруулга авах, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аргыг ашиглахаас гадна аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Үндсэн мэдээлэл

Монгол улсын Засгийн газраас 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг баталж, мөрдөн ажиллах чиглэл өгсөн байна.

Хэнтий аймгийн 2021 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого, тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг, урьд оны үлдэгдэл, сангийн эх үүсвэрээс бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр орон нутгийн төсвийн 162, төсөл сан 84 байгууллагуудыг санхүүжүүлсэн байна.

**БҮЛЭГ1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.****1.1 Дээд шатны төсөвт тодотгол хийгдээгүй байхад 2021 оны 4 дүгээр сард 3,991.0 сая төгрөгөөр төсвийг тодотгосон нь хуульд нийцэхгүй байна.**

1.1.1. Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Хэнтий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 11,582.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 44,239.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 9,501.5 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалаас олгох санхүүжилтийг 457.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,112.1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 557.1 сая төгрөгөөр тус тус буурч, ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 2,227.7 сая төгрөгөөр өссөн байна. Сангийн яам 2021 оны төсвийн жилийн суурь орлогыг 13,568.3 сая төгрөгөөр буюу өмнөх оноос 595.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан байна.

1.1.2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 8 дугаар хуралдаанаар орон нутгийн төсвийн нийт эх үүсвэрийг 88,481.7 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: Орон нутгийн төсвийн орлогыг 14,372.2 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 11,582.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 44,239.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 9,501.5 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 457.2 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 5,623.8 сая төгрөг, бусад сангийн эх үүсвэр 2,705.0 сая төгрөг.

## Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний харьцуулалт

Хүснэгт №1

/сая төгрөг/

Үзүүлэлт	2021 он					
	Сангийн яамнаас хянасан	Анх батлагдсан	2021 оны 4-р сард тодотгосон	Зөрүү	2021 оны 8-р сард тодотгосон	Зөрүү
А	1	2	3	4=3-2	5	6=5-3
ОН-ийн орлого	13,568.3	14,372.2	14,372.2	0.0	15,005.2	633.0
Санхүүгийн дэмжлэг	11,582.9	11,582.9	11,582.9	0.0	13,055.4	1,472.5
ОНХС-аас	9,501.5	9,501.5	9,501.5	0.0	9,758.7	257.2
ТЗШ	44,239.1	44,239.1	44,239.1	0.0	44,902.2	663.1
ЭМДС-аас	457.2	457.2	457.2	0.0	457.2	0.0
Урьд оны үлдэгдлээс	2,030.6	5,623.8	9,614.8	3,991.0	10,361.2	746.4
Сангийн эх үүсвэр		2,705.0	2,705.0	0.0	3,130.4	425.4
<b>ДҮН</b>	<b>81,379.6</b>	<b>88,481.7</b>	<b>92,472.7</b>	<b>3,991.0</b>	<b>96,670.3</b>	<b>4,197.6</b>

1.1.3. Тайлант онд төсвийн тодотголыг 2 удаа хийж, анх батлагдсан төсвийг 4 дүгээр сард 3991.0 сая төгрөгөөр, 8 дугаар сард 4,197.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 96,670.3 сая төгрөгт хүргэн баталжээ. Орон нутгийн төсвийн тодотголын талаар авч үзвэл:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаар батлагдсан төсвийг 3,991.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол хийсэн байна. Энэ нь дээд шатны төсөвт тодотгол хийгээгүй байхад төсвийг нэмж тодотгон Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчсөн, Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 2 дугаарын 17-нд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төсвийн тодотголоор эх үүсвэрийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх 3,991.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тогтмол зардлаас 1,620.3 сая, урсгал шилжүүлгээс, 202.4 сая төгрөгийг тус тус бууруулж, зардлын хувьд цалингийн зардлыг 835.0 сая, эд хогшил урсгал

засварын зардлыг 320.8 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,892.09 сая, хөрөнгийн зардлыг 2,703.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

1.1.4 Монгол улсын 2021 оны 7 дугаар сард УИХ-аас баталсан Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 663.1 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 1,472.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 257.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 11-ний 02 тоот тогтоолоор аймгийн төсвийг 4,197.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 96,670.3 сая төгрөгөөр тодотгон баталсан.

**1.2 Сумын төсвийн орлогод төвлөрүүлсэн 617.8 сая төгрөгийн орлогыг аймгийн төсвийн бусад орлогод татан төвлөрүүлсэн нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.**

1.2.1 Аймгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөөг 14,906.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 24,281.4 сая төгрөгийг төвлөрүүлэн, 9,375.1 сая төгрөг буюу 62.9 хувиар давж биелсэн байна.

Аймгийн төсвийн орлогын биелэлт /нэр төрлөөр/

Хүснэгт №2

/сая төгрөг/

д/д	Орлогын төрөл	Орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
А	1	2	3	4	5
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	7,900.0	10,371.2	131.3	2,471.2
2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(800.0)	(570.0)	71.3	230.0
3	ҮХХ-ийн албан татвар	410.0	503.9	122.9	93.9
4	АТБӨЯХ-ийн албан татвар	420.0	488.9	116.4	68.9
5	Газрын төлбөр	360.0	394.7	109.6	34.7
6	Газрын дуудлага худалдаа	400.0	686.7	171.7	286.7
7	ҮҮЗАУС-ны төлбөр	884.0	1,916.9	216.8	1,032.9
8	Улсын тэмдэгтийн хураамж	163.1	144.4	88.6	(18.7)
9	Хүү торгуулийн орлого	150.0	307.4	205.0	157.4
10	Бусад орлого	549.3	1,341.1	244.1	791.8
11	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө худалдсаны орлого	95.0	189.3	199.2	94.3
<b>Аймгийн орлогын дүн</b>		<b>10,531.4</b>	<b>15,774.6</b>	<b>149.8</b>	<b>5,243.2</b>
1	Үйл ажиллагааны орлого	638.5	584.8	0.9	(53.7)
2	БОНАТ	4.5	3.1	0.7	(1.4)
3	Хөрөнгийн орлого/хад.хүү.ор/	1,023.8	1,307.1	1.3	283.3
4	ҮХХБОрлого /2 хувь/	72.1	372.5	5.2	300.4
5	Галт зэвсгийн албан татвар	49.7	47.7	1.0	(2.0)
6	Улсын тэмдэгтийн хураамж	77.0	73.6	1.0	(3.3)
7	Газрын төлбөр	240.7	241.8	1.0	1.1
8	Ойн нөөц ашигласны төлбөр	439.7	1,267.7	2.9	828.0
9	Агнуурын нөөц ашигласны төлбөр	418.4	1,177.4	2.8	759.0
10	Ус рашаан ашигласны төлбөр	-	13.2		13.2
11	ТТАМ	98.5	67.9	0.7	(30.6)
12	Хог хаягдлын хураамж	463.3	451.9	1.0	(11.4)
13	Малын албан татвар	60.0	1,431.5	23.9	1,371.5
14	Торгууль	661.5	1,088.3	1.6	426.8
15	Бусад орлого	127.4	378.4	3.0	251.0
<b>Сумын орлогын дүн</b>		<b>4,375.0</b>	<b>8,506.9</b>	<b>194.4</b>	<b>4,131.8</b>
<b>Нийт орлогын дүн</b>		<b>14,906.4</b>	<b>24,281.5</b>	<b>162.9</b>	<b>9,375.1</b>

Аймгийн төсөвт төвлөрөх орлогыг 10,331.4 сая төгрөгөөр баталж, тодотголоор 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 10,531.4 сая төгрөгөөр баталсан. Төсвийн орлого гүйцэтгэлээр 15,774.6 сая төгрөг буюу 149.8 хувиар давж биелсэн байна.

Аймгийн орлогын гүйцэтгэл нийт дүнгээр бүх сум биелсэн байна. Үүнийг орлогын нэр төрөл, сумдаар авч үзвэл. Үүнд:

- Бор-Өндөр сумын үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 1,006.4 сая төгрөг, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,492.2 сая төгрөг, Хэрлэн сумын бусад орлого 991.7 сая төгрөг, хүү торгууль 157.4 сая төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 286.7 сая төгрөг, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 712.9 сая төгрөгөөр давж биелсэн байна.
- Газрын төлбөрийг Баян-Адарга, Батноров, Бор-Өндөр, Жаргалтхаан, Мөрөн, Өлзийт, Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал сумд, үл хөдлөх хөрөнгийн орлогыг Батноров, Батширээт, Баян-Адарга, Баянхутаг, Галшар, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн сумд тус тус биелүүлээгүй үзүүлэлттэй байна.

- ✓ Аудитаар төсвийн орлоготой холбоотой нийт 617.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:
  - ✓ *Өмнөдэлгэр, Батширээт сум 355.7 сая төгрөгийн ойн нөөц ашигласны төлбөр, Батноров, Баян-Овоо, Баянхутаг, Мөрөн, Норовлин, Дэлгэрхаан, Хэрлэн сум 262.1 сая төгрөгийн агнуурын нөөц ашигласны төлбөр зэрэг нийт 617.8 сая төгрөгийн сумын төсөвт төвлөрүүлсэн орлогоос аймгийн төсвийн бусад орлого дансанд татан төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1-т “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь зарлагаас бага тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн ... 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.*
  - ✓ *Тайлант онд өмч, хөрөнгө худалдсаны орлого 95.0 сая төгрөг батлагдсанаас 189.3 сая төгрөг буюу 199.3 хувийн биелэлттэй байна. Тус орлогын гүйцэтгэлд түүврийн аргаар сорил хийхэд Биндэр сумын ЗДТГ-ын өмч хамгаалах байнгын комиссын хурлын тэмдэглэлд Ланд 105 маркийн автомашиныг 10.0 сая төгрөгөөр үнэлж, актлах хөрөнгийн жагсаалтад оруулж аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2021.11.09-ний өдрийн 438 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Уг хөрөнгийг аймгийн ОНӨГ-аас үнэлж, дүгнээгүй, аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/585 тоот захирамж гаргуулж, актлах хөрөнгийн жагсаалтад оруулж баталгаажуулсан боловч тухайн хөрөнгийг тодорхой үнэлгээ гаргаж худалдан борлуулсан эсвэл устгалд оруулсан эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь орон нутгийн өмчид бүртгэлтэй байгаа хөрөнгийг үнэлж, шийдвэр гаргах ажил хангалтгүй байгааг харуулж байна.*

1.2.2. Сумын төсөвт төвлөрөх орлогыг 3,936.9 сая төгрөгөөр баталж, тодотголоор 438.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 4,375.0 сая төгрөгөөр баталсан. Төсвийн орлого гүйцэтгэлээр 8,506.9 сая төгрөг буюу 194 хувиар давж биелсэн байна.

Орлогыг нэр төрлөөр авч үзвэл: Хөрөнгийн орлого, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, ойн нөөц ашигласан, агнуурын нөөц ашигласны төлбөр, малын албан татвар, торгууль, бусад орлого нийт 4,273.4 сая төгрөгөөр давж, биелсэн, үйл ажиллагааны орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр, хог хаягдлын хураамж, борлуулалтын орлогод ногдох албан татвар, галт зэвсгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж зэрэг орлогууд нэр төрлөөрөө тасарсан үзүүлэлттэй байна.

- Хөрөнгийн орлогыг Баянхутаг сум 16.1 сая төгрөг, Дархан сум 11.2 сая төгрөг, Өмнөдэлгэр 16.6 сая төгрөг, Батширээт сум 11.3 сая төгрөг, Биндэр 15.5 сая төгрөг, Дадал сум 15.7 сая төгрөг, Батноров сум 11.7 сая төгрөг, Хэрлэн сум 142.1 сая төгрөг, Бор-Өндөр сум 19.6 сая төгрөг, Бэрх тосгон 13.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь тус суманд иргэдийн хадгаламж өссөнтэй холбоотой байна.
- Үл хөдлөх хөрөнгийн борлуулсны орлогыг Бор-Өндөр сум 137.0 сая төгрөгөөр, Хэрлэн сум 95.5 сая төгрөгөөр биелүүлсэн нь газрын дуудлага худалдаанаас орсон орлого өссөнөөс шалтгаалжээ.
- Ойн нөөц ашигласны төлбөрийг Батширээт сум 306.3 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 437.4 сая төгрөгөөр биелсэн нь самар түүж, худалдах борлуулах зөвшөөрөл олгосноос, Норовлин сум 18.4 сая төгрөгөөр давж биелсэн нь ЗГ-ын тогтоолоор 1 м3 модны экологи, эдийн засгийн үнэлгээ нэмэгдсэнээс, Дадал сум 37.4 сая төгрөгөөр биелүүлсэн нь Онон балжийн байгалийн цогцолборт газрын ойн цэвэрлэгээний гоожингийн үнэ орсноор тус тус давж биелжээ.
- Агнуурын нөөц ашигласны төлбөрийг Баянхутаг сум 94.1 сая төгрөгөөр давуулсан нь зээр агнах зөвшөөрөл олгосноор, Дэлгэрхаан сум 254.9 сая төгрөг, Жаргалтхаан сум 81.9 сая төгрөг, Норовлин сум 40.6 сая төгрөг, Батноров сум 65.0 сая төгрөг, Баян-Овоо сум 169.7 сая төгрөг, Мөрөн сум 38.2 сая төгрөг, Хэрлэн сум 37.8 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн нь шонхор шувуу барих зөвшөөрөл олгосонтой холбоотой байна.
- Малын тоо толгойн албан татварын орлогыг тайлант онд төлөвлөөгүйтэй холбоотойгоор 1,386.8 сая төгрөгийн орлого орсон байна.
- Торгуулийн орлого Жаргалтхаан сум 13.0 сая төгрөг, Цэнхэрмандал сум 102.7 сая төгрөг, Биндэр сум 18.7 сая төгрөг, Норовлин сум 14.5 сая төгрөг, Мөрөн сум 13.4 сая төгрөг, Хэрлэн сум 166.1 сая төгрөг, Бор-Өндөр сум 64.4 сая төгрөг, Бэрх тосгон 11.1 сая төгрөгөөр давж биелсэн нь хүн амын төвлөрөл, хот хоорондын зам дагуу, Цагдаагийн хэсэг байрладаг сумдад болон Өршөөлийн тухай хуулиар тодорхой заасан хугацаанд төлсөн тохиолдолд 50 хувийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой давж биелжээ.
- Бусад орлого Цэнхэрмандал сум 15.5 сая төгрөг, Норовлин сум 10.6 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 16.4 сая төгрөг, Хэрлэн сум 45.1 сая төгрөг, Бор-Өндөр сум 78.2 сая төгрөг, Баян-Овоо сум 10.2 сая төгрөг, Бэрх сум 23.7 сая төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.

Дараах орлого тасарсан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого Ковид-19 цар тахлын хөл хориотой холбоотой хувиараа бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, орлого буурсантай холбоотой тасарсан.
- Түгээмэл тархац ашигт малтмал цар тахлын улмаас барилгын ажил хийгдээгүйгээс зогсонги байдалтай болсноор, мөн тусгай зөвшөөрлийн шаардлага хангаж ажиллуулах аж ахуйн нэгж байхгүйгээс шалтгаалсан.

- Хог хаягдлын хураамж тасарсан нь айл өрхийн хогны төлбөрийг төрөөс хөнгөлөлт үзүүлсэн боловч гүйцэтгэлээр орлого дутуу орсонтой холбоотой.

Харьяа байгууллагад хийсэн аудитаар орлогын гүйцэтгэл, төвлөрүүлэлттэй холбоотой 380.9 сая төгрөгийн 26 зөрчил илрүүлснээс 3.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 12.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 365.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 20 зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:

- Орлогын нэр төрлөөр Галшар 12.0 сая төгрөг, Баянхутаг 3.6 сая төгрөг, Баянмөнх 1.1 сая төгрөг, Дархан сумын 6.9 сая төгрөг, Дэлгэрхаан 6.6 сая төгрөг, Жаргалтхаан 2.8 сая төгрөг, Цэнхэрмандал 16.4 сая төгрөг, Өмнөдэлгэр 7.2 сая төгрөг, Биндэр 16.6 сая төгрөг, Баян-Адарга 25.7 сая төгрөг, Дадал сумын 9.2 сая төгрөг, Батноров 4.2 сая төгрөг, Баян-Овоо 3.7 сая төгрөг, Мөрөн 9.3 сая төгрөг, Хэрлэн сумын 155.9 сая төгрөг, Гурванбаян 3.0 сая төгрөг, нийт 284.2 сая төгрөгөөр тасалсан
- Батширээт сумын Засаг дарга орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын тогтмол зардлын зарцуулаагүй үлдэгдэл 49.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.
- Биндэр сум, Дадал сумын Засаг дарга малын тоо толгойн албан татварыг орон нутгийн хөгжлийн санд 14.1 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.
- Биндэр сумын Засаг даргын тамгын газар Хурхын голын гүүрний хураамж 3.7 сая төгрөгийг, Дадал сум Засар даргын тамгын газар Онон голын гүүрний хураамж 5.2 сая төгрөгийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн.
- Галшар сумын Засаг даргын тамгын газар төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлснээс орсон орлогоос 2.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй.
- Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газар төсвийн орлогод төвлөрүүлэх 1.6 сая төгрөгийн бэлчээрийн төлбөрийг байгууллагын нэмэлт дансанд төвлөрүүлсэн.
- Батноров сумын Орон нутгийн хөгжлийн санд сумын өмнөх оны үлдэгдлээс 19.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.
- Хэнтий Нийтлэг үйлчилгээний ОНӨААТҮГ түрээсийн орлогын 40%-ийг 0.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.

1.3 Сум хөгжүүлэх сангийн орлогыг 1,511.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,639.6 сая төгрөгийг төвлөрүүлж, биелэлт 128.2 сая төгрөгөөр буюу 8.5 хувиар давж биелсэн нь “Бусдадаа боломж олгоё” аяныг зохион байгуулсан ажлын үр дүн байна.

1.3.1 Орон нутгийн хөгжлийн санд олгох 9,758.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 11,248.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 1,489.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь малын тоо толгойн албан татварын төвлөрүүлэлт нөлөөлсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Хүснэгт №3

/сая төгрөг/

д/д	Сумдын нэр	Орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
А	1	2	3	4=3/2	5=3-2
1	Галшар	615.9	656.9	106.7	41.0
2	Баянхутаг	87.1	155.5	178.5	68.4
3	Баянмөнх	72.9	150.0	205.9	77.2
4	Дархан	528.4	607.2	114.9	78.8
5	Дэлгэрхаан	69.5	117.3	168.7	47.8
6	Жаргалтхаан	136.9	196.9	143.8	60.0
7	Цэнхэрмандал	161.3	221.7	137.4	60.4
8	Өмнөдэлгэр	175.5	315.8	179.9	140.3
9	Батширээт	140.2	191.1	136.4	51.0

10	Биндэр	127.8	241.3	188.8	113.5
11	Баян-Адрага	118.2	172.4	145.9	54.2
12	Дадал	119.9	151.6	126.5	31.7
13	Норовлин	157.4	242.6	154.1	85.2
14	Батноров	159.3	295.6	185.5	136.3
15	Баян-Овоо	101.0	217.2	215.1	116.2
16	Мөрөн	83.2	115.5	138.7	32.2
17	Хэрлэн	633.9	755.6	119.2	121.7
18	Бор-Өндөр	931.0	957.4	102.8	26.4
19	Бэрх	90.0	90.0	100.0	0.0
20	Гурванбаян	40.0	57.9	144.7	17.9
21	Өлзийт	40.0	57.8	144.5	17.8
22	Хэрлэнбаян-Улаан	20.0	31.4	157.0	11.4
23	Хэрлэн хот тохижилт	437.3	437.3	100.0	0.0
24	Аймгийн ОНХС	4712.1	4812.1	102.1	100.0
	<b>Дүн</b>	<b>9758.7</b>	<b>11248.0</b>	<b>115.3</b>	<b>1489.2</b>

1.3.2 Байгаль хамгаалах сангийн орлогыг 102.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 96.7 сая төгрөгийг төвлөрүүлж 5.3 сая төгрөг буюу 5.4 хувиар биелүүлээгүй байна. Орлогын төлөвлөгөөг Баян-Адрага сум 4.5 хувиар, Мөрөн сум 85.7, Цэнхэрмандал сум 63.4 хувиар тус тус тасалсан байна.

Тусгай сангийн орлогын гүйцэтгэл

Хүснэгт №4

/сая төгрөг/

№	Сумдын нэр	СХС			ЖБДС			БХС		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Галшар	65.3	54.0	(11.2)	26.0	21.6	(4.4)	-	1.0	1.0
2	Баянхутаг	155.2	7.8	(147.3)	85.4	12.0	(73.3)	1.0	1.5	0.5
3	Баянмөнх	35.0	29.1	(5.9)	15.0	43.4	28.4	-	-	-
4	Дархан	20.0	104.3	84.3	10.2	38.7	28.5	-	2.6	2.6
5	Дэлгэрхаан	20.0	32.7	12.7	20.0	14.2	(5.8)	-	8.3	8.3
6	Жаргалтхаан	45.4	67.7	22.3	4.1	13.8	9.7	6.7	10.0	3.3
7	Цэнхэрмандал	30.0	84.0	54.0	25.0	19.9	(5.1)	50.0	18.3	(31.7)
8	Өмнөдэлгэр	20.0	97.8	77.8	40.0	31.0	(9.0)	-	1.5	1.5
9	Батширээт	82.3	76.5	(5.8)	48.7	23.4	(25.3)	-	0.8	0.8
10	Биндэр	50.0	55.5	5.6	51.7	19.8	(31.9)	10.0	11.9	1.9
11	Баян-Адрага	50.0	64.7	14.7	30.0	16.3	(13.7)	11.0	10.5	(0.5)
12	Дадал	69.4	61.2	(8.2)	26.1	39.4	13.3	15.5	17.6	2.1
13	Норовлин	35.8	67.0	31.3	28.0	19.0	(9.0)	-	-	-
14	Батноров	53.0	64.5	11.5	44.5	51.5	7.0	5.0	7.1	2.1
15	Баян-Овоо	33.9	75.7	41.8	17.1	12.1	(5.0)	-	1.8	1.8
16	Мөрөн	2.5	30.1	27.6	50.0	14.4	(35.6)	2.8	0.4	(2.4)
17	Хэрлэн	407.2	412.2	5.0	311.0	96.3	(214.7)	-	2.2	2.2
18	Бор-Өндөр	289.4	163.0	(126.4)	42.1	17.5	(24.6)	-	1.2	1.2
19	Бэрх	22.5	70.7	48.2	21.0	65.2	44.2	-	-	-
20	Гурванбаян	18.0	14.9	(3.1)	-	-	-	-	-	-
21	Өлзийт	3.6	2.7	(0.9)	-	-	-	-	-	-
22	Хэрлэнбаян-Улаан	3.1	3.2	0.2	-	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>1,511.4</b>	<b>1,639.6</b>	<b>128.2</b>	<b>895.8</b>	<b>569.5</b>	<b>(326.4)</b>	<b>102.0</b>	<b>96.7</b>	<b>(5.4)</b>

**ХОЁР. НИЙТ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 89.9 ХУВЬТАЙ БАЙНА.**

**2.1 Төсвийн тодотголоор тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийг 663.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч оны эцэст төсвийн зарцуулагдаагүй 2,440.0 сая төгрөгийн үлдэгдлийг буцааж төвлөрүүлсэн нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, хуваарилаагүй байна.**

2.1.1 Хэнтий аймгийн 2021 оны төсвийн нийт зарлага тодотгосон төсвөөр 96,670.3 сая төгрөгөөр батлагдсанаас 86,864.7 сая төгрөгийг зарцуулж, 89.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 9,805.6 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна. Энэ нь өмнөх оны зарлагын гүйцэтгэлээс 12.5 хувиар өссөн байна.

Төсвийн нийт зарлагын 9,805.6 сая төгрөгийн хэмнэлтийн 30.9 хувь тусгай зориулалтын шилжүүлэг, 69.1 хувь орон нутгийн төсөв эзэлж байна. Орон нутгийн төсвийн хэмнэлтийн 35.9 хувь нь СХС, ЖДБД сангаас олгох зээлийг түр хугацаагаар зогсоосон нь нөлөөлж байна.

Төсвийн нийт зарлагын 43.8 хувийг орон нутгийн төсөвт байгууллагуудын зардал, 56.2 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардал эзэлж байна.

*Нийт зарлагын гүйцэтгэлийг төсвийн захирагчаар болон эдийн засгийн ангиллаар*


Хүснэгт №5

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2021 он						Зөрүү
		Орон нутгийн байгууллагууд		Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд		Нийт		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тодотгосон төсөв - 2	Гүйцэтгэл	
Б	1	2	3	4	5	6	7	8=6-7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,181.6	44,782.6	38,009.9	51,887.7	48,854.8	96,670.3	86,864.7	9,805.6
УРСГАЛ ЗАРДАЛ	68,903.4	26,279.9	24,215.9	51,887.7	48,854.8	78,167.6	73,070.7	5,096.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,214.6	25,448.3	23,445.6	50,506.3	47,699.3	75,954.6	71,144.9	4,809.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,286.0	10,348.7	10,039.6	33,007.1	31,892.0	43,153.4	41,931.5	1,221.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,991.8	1,403.3	1,318.4	4,528.0	4,167.8	5,933.5	5,486.2	447.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,433.8	2,586.6	2,032.3	6,181.4	5,836.1	8,768.0	7,868.4	899.6
Хангамж, бараа материалын зардал	2,170.2	760.1	749.0	1,010.9	997.5	1,771.0	1,746.5	24.5
Нормативт зардал	3,301.4	169.3	167.3	2,762.5	1,860.9	2,931.9	2,028.2	903.7
Эд хогшил, урсгал засварын зардал	2,547.7	889.8	881.9	1,330.1	1,299.8	2,220.0	2,181.7	38.3
Томилолт, зочны зардал	308.4	183.5	166.7	83.3	75.4	267.0	242.1	25.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,132.9	4,195.0	3,832.5	277.3	272.7	4,672.3	4,105.2	567.1
Бараа үйлчилгээний бусад зардал	4,042.4	4,911.9	4,258.0	1,325.6	1,297.1	6,237.5	5,555.1	682.5
ТАТААС	367.0	53.9	40.1	244.0	244.0	297.9	284.2	13.8
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	31.0	53.9	40.1	0.0	0.0	53.9	40.2	13.8
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	336.0	0.0	0.0	244.0	244.0	244.0	244.0	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,321.8	777.7	730.1	1,137.4	911.5	1,915.1	1,641.6	273.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	153.0	176.6	176.6	0.0	0.0	176.6	176.6	0.0
Бусад урсгал шилжүүлэг	1,168.8	601.1	553.5	1,137.4	911.5	1,738.5	1,465.0	273.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,364.0	15,145.1	12,870.2	0.0	0.0	15,145.1	12,870.2	2,274.9
Барилга байгууламж		1,850.0	1,850.0	0.0	0.0	1,850.0	1,850.0	-
Их засвар		50.0	0.0	0.0	0.0	50.0	-	50.0
Бусад хөрөнгө		13,245.1	11,020.2	0.0	0.0	13,245.1	11,020.2	2,224.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	914.2	3,357.6	923.8	0.0	0.0	3,357.6	923.8	2,433.8

Орон нутгийн төсвийн нийт зардал 44,782.6 сая төгрөгөөр батлагдсанаас 38,009.9 сая төгрөг буюу 84.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бөгөөд нийт зардлын 63.7 хувийг урсгал зардал, 33.9 хувийг хөрөнгө оруулалтын зардал, 2.4 хувийг эргэж төлөгдөх зээлийн дүн эзэлж байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл. График №1



Дээрх графикаас харахад нийт төсвийн зарлагын 39.9 хувийг цалин, шимтгэлийн зардалд, 5.3 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 5.2 хувийг хангамж, бараа материал, нормативт зардал, эд хогшил, урсгал засвар, томилолтын зардалд, 21.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд, 2.0 хувийг урсгал шилжүүлгийн зардалд, 33.9 хувийг хөрөнгийн зардалд, 2.4 хувийг эргэж төлөгдөх зээлд зарцуулсан байна.

2.1.2 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн нийт зардал 51,887.7 сая төгрөгөөр батлагдсанаас 48,854.8 сая төгрөгийн буюу 94.1 хувийн гүйцэтгэлтэй, харилцах дансанд 152.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Харилцах дансны үлдэгдэл нь Эрүүл мэндийн төвүүдийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Тусгай зориулалтын шилжүүлэг, төсвийн ерөнхийлөн захирагчдаар

Хүснэгт №6

/сая төгрөг/

Санхүүжилтийн эх үүсвэр	ТЗШ		Тогтмол зардал		ЭМД		Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		Нийт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
БШУС-ын сайд	35,437.0	33,057.5	5,725.1	5,401.7					41,162.2	38,459.2
ЭМ-ийн сайд	8,562.9	8,562.9	725.6	694.2	457.2	371.8	-	0.1	9,745.7	9,629.0
ХНХ-ын сайд	294.3	289.3	53.2	53.2					347.5	342.6
БХБ-ын сайд	607.9	552.4	24.3	24.3					632.2	576.7
<b>Нийт дүн</b>	<b>44,902.2</b>	<b>42,462.1</b>	<b>6,528.3</b>	<b>6,173.4</b>	<b>457.2</b>	<b>371.8</b>	<b>-</b>	<b>0.1</b>	<b>51,887.6</b>	<b>49,007.5</b>

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нийт зарлагын 78.9 хувийг БШУС-ын, 19.1 хувийг ЭМС-ын, 2.0 хувийг бусад сайдын багцын байгууллагууд эзэлж байна. Нийт төсвийн зарцуулаагүй үлдэгдэлд 2,795.0 сая төгрөг байгаагаас тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зарцуулаагүй үлдэгдэл, 2,440.0 сая төгрөг, байр ашиглалтын холбоотой тогтмол зардлаас 355.0 сая төгрөг байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэхээс 2,489.2 сая төгрөг буюу 49.2 сая төгрөгөөр илүү төвлөрүүлсэн байна. Энэ нь Батширээт сумын ЕБС, Цэцэрлэгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тогтмол зардлын зарцуулаагүй үлдэгдэл бөгөөд улс болон орон нутгийн төсвийн хоорондын тооцоог хангалтгүй хийж Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д заасантай нийцэхгүй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн СӨБ-ын төсвийг 1,176.4 сая төгрөгөөр бууруулж, Ерөнхий боловсролын сургуулийн төсвийг 1,855.3 сая төгрөг нэмэгдүүлж тодотгосон боловч тайлант оны эцэст СӨБ 958.9 сая төгрөг, ЕБС 1,420.6 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлэн ажилласан нь төсвийн хуваарилалт үндэслэлгүй хийгдсэнийг харуулж байна.

#### Тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №7

ТЗШ-ийн байгууллагууд	Анх батлагдсан	Тодотгосон	/сая төгрөг/
			Зөрүү /+дутуу, -илүү/
СӨБ	12,765.5	11,592.1	1,173.4
ЕБС	21,989.7	23,845.0	(1,855.3)
ЭМТ	8,562.9	8,562.9	-
ХГБЗХГ, ГХБХБГ	921.0	902.2	18.8
<b>Нийт</b>	<b>44,239.1</b>	<b>44,902.2</b>	<b>(663.1)</b>

Төсвийн тодотголоор багш хөгжлийн төвийг тохижуулахаар 487.5 сая төгрөгийг Ерөнхий боловсролын сургуулиудын багаж техник хэрэгслийн зардалд зохицуулсныг 14.5-19.5 сая төгрөгийн үнэтэй нийт 473.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан. Мөн СӨБ-иудын төсөв хооронд 140.0 сая төгрөгөөр зохицуулалт хийж, 17.5 сая төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмж худалдан авсан.

